

Холбоо, навигаци, бодит ажиглалтын тоног төхөөрөмжийн
ашиглалт, техникийн бэлэн байдлын
тухай

2014 оны 12-р сарын 15

2014 оны 8-р сарын 19-ний өдрийн 20 цаг 11 минутаас 20 цаг 38 минут хүртэл 27 минут Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн **SDD** дэлгэц, ажлын байрны үндсэн **VCCS** дэлгэцүүд, **AFTN** болон ажлын байрны бүх тоног төхөөрөмж унтарч нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа тасалдсан. Энэ үед Чингис хаан нисэх буудалд буулт үйлдсэн 1 агаарын хөлөг, бүсийн Төв, Говь, Дорнод, Алтай секторт нислэг үйлдэж байсан **MNG84, UAL898, AFL206, TSO9999** аяллын олон улсын өнгөрөлтийн 3 нислэг, орон нутгийн 1 нийт 5 агаарын хөлөгтэй 27 минутын хугацаанд хоёр талын радио холбоо тасарч, хөдөлгөөний үйлчилгээ үзүүлж чадаагүй. Цахилгаан тэжээлийн системд богино холбоо үүсч тоног төхөөрөмж унтрах үед “Аэронет” сүлжээний **Alcatel 1322VD** маркийн шилэн кабелийн нягтруулгын төхөөрөмж нь батерейнаас ажиллаагүй байна. Мөн цамхагийн нөөц ажлын байрны тоног төхөөрөмжийн шаардлага хангагдаагүй, бүсийн удирдлагын нөөц ажлын байр байхгүй байна. НААХЗГ-ын байцаагчийн **405/14, 399/14** тоот дүгнэлтэд 6 төрлийн шаардлага тавьж, ИТА-чид ажилдаа хайнга хандаж, цахилгаан тэжээлийн кабелийг гэмтээж богино холболт үүсгэснээс 2014 оны 8-р сарын 19-ний 20 цаг 11 минутаас 20 цаг 38 минут хүртэл НХУТ-ийн үйл ажиллагаа доголдсон байна гэж дүгнэсэн. Олон улсын өнгөрөлтийн болон орон нутгийн нислэгийн 5 агаарын хөлөгтэй хоёр талын радио холбоо бүрэн алдагдсан нислэгийн онцгой тохиолдол болсон бөгөөд зөрчлийн ангиллын хувьд **ноцтой зөрчил**-ийн ангилалд хамаарагдана.

Агаарын хөдөлгөөний үйлчилгээний албаны дарга Х.Энхбаатар байцаагчийн **399/14** тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа албан тоотоор мэдэгдсэн байна.

Автоматжуулалтын нөөц ажлын байрны дэлгэц суурилуулахаар кронштейн дээр өрөмдлөг хийсэн ИТА-чид гэрэлтүүлэгийн цахилгааны утсанд богино холбоо үүсгэснээс **UPS** гаралтаа хаасан тул тэжээгдэж байсан тоног төхөөрөмжүүд бүгд унтарсан байна. Уг кронштейнийг анх буруу харуулж суурилуулсныг хүлээн авсан комисс илрүүлээгүй байна. Үүнтэй холбогдуулан тус албанаас “Техник хангалт үйлчилгээний алба”-ны хөдөө орон нутагт байгаа холбоо, навигацийн, бодит ажиглалтын, сансарын тоног төхөөрөмжийн байдалтай танилцахад доорхи дутагдал нийтлэг шинж чанартай илэрч байна. Үүнд:

- Агаарын замын нислэгийн хөдөлгөөний эрчимжилт, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлж байгаа арга, нислэгийн удирдагчийн ажлын ачаалалтай уялдуулан холбоо, навигаци, бодит ажиглалтын тоног төхөөрөмжийг оновчтой сонгож, байршуулах ажил судалгаа тооцоонд тулгуурлаж хийгдээгүй.
- Бодит ажиглалтын радиолокаторын системд гэмтэл гарсан үед нөөц системгүй байхгүй, **ADS-B** системийг туршиж байгаа.
- Гэрчилгээжээгүй навигацийн, цаг агаарын бодит ажиглалтын автомат (**DME435, AWOS**) тоног төхөөрөмжийг нислэгийн үйл ажиллагаанд зориулан туршилтын журмаар ажиллуулж байна. Мөн олноор үйлдвэрлэгдсэн шууд ашиглах боломжтой бодит ажиглалтын, навигацийн тоног төхөөрөмжийг 4 жил буюу ашиглах ресурсийн 30 хүртэл хувийг туршилтанд зориулсан байна.